

ШУТИС-ийн профессор, багш нараас эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь ШУТИС дээр хэрэгжиж буй эрдэм шинжилгээний төсөл, аж ахуйн гэрээт ажил гүйцэтгэх, үйлчилгээ /цаашид “төсөл” гэх/ үзүүлэх үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоож, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Төсөл нь эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг шударга өрсөлдөөн, гэрээ захиалгын үндсэн дээр онол, арга зүйн өндөр түвшинд гүйцэтгэж, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан үр дүнг бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааг тусгасан баримт бичиг болно.

Хоёр. Төслийн хэлбэр

Эрдэм шинжилгээний төслүүд нь дараах 5 хэлбэртэй байна. Үүнд:

- 2.1 Улсын захиалгат,
- 2.2 Аж ахуйн гэрээт,
- 2.3 ШУТИС-ийн Технологийн сангийн,
- 2.4 Олон улсын хамтарсан,
- 2.5 Бусад (Мэргэжлийн зөвлөгөө өгөх, экспертиз хийх, гадаад, дотоодын төслийн урьдчилсан судалгаа хийх, төсөл бэлтгэх зорилгоор хурал, семинар зохион байгуулах, гэх мэт).

Гурав. Төслийн гэрээ, баталгаажуулалт

- 3.1 ШУТИС-ийн нэрийн өмнөөс байгуулах гэрээнд ректор болон асуудал эрхэлсэн проректор гарын үсэг зурна.
- 3.2 Бүрэлдэхүүн сургуулиас гүйцэтгэх төслийн гэрээнд гэрээг санаачлан хэрэгжүүлж байгаа профессор болон холбогдох төвийн захирал гарын үсэг зурж, бүрэлдэхүүн сургуулийн захирал баталж гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

Дөрөв. Төслийг мэдээллийн баазад бүртгүүлэх

- 4.1 Шинээр эхэлж буй төслийн талаархи мэдээллийг төслийн удирдагч бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн хуралд танилцуулна.

- 4.2 Төсөл гэрээг байгуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор уг төслийн карт болон гэрээний 1 хувийг ШУТИГ-т ирүүлнэ.
- 4.3 Төслийг ШУТИС-ийн Төслийн мэдээллийн баазад бүртгэнэ.
- 4.4 Зөвхөн уг баазад бүртгэгдсэн төслөөр профессорын багуудын “Б” цагийн гүйцэтгэл, аттестатчлал ба багшийн шалгаруулалтын гол үзүүлэлт болгож дүгнэнэ. Мэдээллийн баазад бүртгэгдээгүй төсөл, гэрээт ажлыг профессорын багийн үйл ажиллагааг дүгнэхэд болон бүтээлийн жагсаалт, тодорхойлолт гаргахад тооцохгүй.

Тав. Төслийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх харилцаа

- 5.1 ШУТИС-ийн нэрийн өмнөөс төсөл хэрэгжүүлэхэд тус сургуулийн ажлын өрөө, сургалтын анги танхим, лабораторын багаж, тоног төхөөрөмж, компьютер болон бусад техник хэрэгсэлийг ашиглана.
- 5.2 Төслийг хэрэгжүүлэхэд ШУТИС-ийн нэр хүнд, ажлын байр, лабораторын материаллаг бааз болон урьд хуримтлагдсан мэдээллийн баазыг ашигласан зардлын хэмжээ нь төслийн төсөвт өртөгийн 15 хувиас багагүй байхаар тооцож гэрээг байгуулна. Энэхүү шимтгэлийг төсөл бүрээс авах ба төслийн нийт мөнгөн дүнгийн 5 хувийг ШУТИС-ийн эрдэм шинжилгээний дансанд, 5-аас 10 хүртэл хувийг бүрэлдэхүүн сургуулийн дансанд шилжүүлэх журам баримтлана.
- 5.3 Эрдэм шинжилгээний санд хуримтлагдсан хөрөнгийг эрдэм шинжилгээний төсөл санхүүжүүлэх, эрдэмтдийн бүтээлийг хэвлэн нийтлэх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, технологи дамжуулах үйл ажиллагаанд зарцуулна.
- 5.4 Төслийн санхүүжилтийг ШУТИС-ийн эрдэм шинжилгээний данс, бүрэлдэхүүн сургуулийн дансаар дамжуулан олгоно.

Зургаа. Төслийн гүйцэтгэлийн хяналт, үр дүнг хүлээлгэж өгөх

- 6.1 Төслийн явцын тайлан, үр дүнг хагас жил тутам хэлэлцүүлж байна. Төслийн гүйцэтгэлд дор дурдсан чиглэлээр хяналт тавина. Үүнд:
 - Төслийн хүрээнд гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын арга зүйн түвшин
 - Төслийн санхүүгийн үйл ажиллагаа
 - Төслийн үр дүн, гүйцэтгэх хугацаа
- 6.2 Улсын захиалгат төслийн үр дүнг Засгийн газрын 2005 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх журам”-ын 9 дүгээр зүйлд заасны дагуу хүлээлгэн өгч, санхүүгийн тооцоог дуусгавар болгоно.
- 6.3 ШУТИС-ийн Технологийн сангийн төслийн үр дүнг их сургуулийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэж өгнө.
- 6.4 Аж ахуйн гэрээт ажлын үр дүнг тухайн санхүүжүүлэгч аж ахуйн нэгж, компанитай байгуулсан гэрээнд харилцан тохиролцсон хэлбэрээр хүлээлгэн өгнө.

Долоо. Урамшуулал

- 7.1 Төслийн нийт мөнгөн дүнгээс ШУТИС болон бүрэлдэхүүн сургуульд шилжүүлсэн шимтгэлүүдийг тухайн төслийг хэрэгжүүлж буй профессорын багаас сургуульд оруулсан орлогод тооцож үзнэ.
- 7.2 Төслийн хүрээнд тус сургуулийн эрдэм шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлэх зорилготой шинээр тоног төхөөрөмж, программ хангамж, ном сурах бичиг оруулж ирсэн эрдэмтэн, багш нарт уг төхөөрөмжийг судалгаа, шинжилгээ, аж ахуйн гэрээт ажилд ашигласнаар олох 1 жилийн орлогын 15 хүртлэх хувьтай тэнцэх урамшууллыг 1 удаа олгож болно.
- 7.3 Хэрэв тус тоног төхөөрөмж, программ хангамжийг 7.2-т зааснаар эрдэм шинжилгээний төсөлд ашиглаж орлого олох боломжгүй, зөвхөн сургалтанд ашиглах тохиолдолд 2008 оны 06 сарын 02-ны өдрийн 176 тоот тушаалаар батлагдсан “Профессор багш нарын ажлын кредит тооцох тухай” журмын 3.1 заалтыг баримтална.